

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

(2024 оны эхний хагас жилийн байдлаар)

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь
				Он	Түвшин		
<b>"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮНИЙ ХӨГЖИЛ БҮЛГИЙН ХҮРЭЭНД:</b>							
<b>3.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.</b>							
<b>3.2.НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛНА.</b>							
<b>Зорилго 3.2.1.</b> Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.							
3.2.1.1	Нийгмийн даатгалын шударга тогтолцоонд шилжүүлэх;	-	Арга хэмжээний хэрэгжилт	-	-	Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулыг баталсан. Багц хуулийн шинэчлэлийн хүрээнд тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлэх чиглэлээр дараах асуудлууд тусгагдан хэрэгжиж байна. Үүнд: - Даатгуулагч дараалсан 5 жилийн дундаж цалин хөлснөөс тэтгэврээ тогтоолгоно. - 2019-2023 онд 6, эсхүл 7 жилийн дундаж цалин хөлснөөс тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг 5 жилийн дундаж цалин хөлснөөс тооцон өөрчлөх боломжтой болсон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 55.5 мянган иргэн тэтгэврээ 5 жилийн дундаж цалин хөлснөөс өөрчлөн тогтоолгосон байна. - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйл (Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт)-ээр өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан бол түүний нөхөр /эхнэр/-ийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ, тэтгэврийн нэмэгдлийн хэмжээ нь нас барсан тэтгэвэр авагчийн авч байсан тэтгэврийн 20 хувьтай тэнцүү байхаар заасан бөгөөд энэ арга хэмжээнд 500 орчим ахмад хамрагдаж оны эхний 5 сарын байдлаар 20 хувийн нэмэгдэлд 210.0 сая төгрөг олгоод байна. - Олон жил шимтгэл төлж ажилласан даатгуулагч илүү өндөр тэтгэвэр авах нөхцөл бүрдсэн. Өөрөөр хэлбэл тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд дундаж цалин хөлснөөс 1.5 хувиар тооцон нэмэгдүүлж байсан бол шимтгэл төлж ажилласан жил	100%

						<p>тутамд 2 хувиар тооцох бөгөөд энэ зохицуулалтыг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн эхлэн мөрдөнө.</p> <p>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр” заасан. Уг хуулийн зохицуулалтыг 2025 оноос эхлэн мөрдөнө.</p> <p>Шинээр тэтгэвэр тогтоолгосон хүний тэтгэвэр бодох цалин хөлсөнд өнөөгийн үнэ цэнийг тодорхойлсон Засгийн газрын жил бүр батлах “итгэлцүүр” хэрэглэдэг болсноор тэтгэврийн худалдан авах чадвар нэмэгдэх юм.</p>	
3.2.1.2	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	-	Тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдүүлнэ	-	-	<p>Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор 2024 оны 04 сарын 01-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон. Уг тэтгэврийн нэмэгдэлд 2024 онд 449.0 тэрбум төгрөг зарцуулахаар тусгагдсан.</p>	100%
<b>ДУНДАЖ ХУВЬ</b>							<b>100%</b>